

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ургамал, малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлыг хангах арга хэрэгслийг сайжруулах төслийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2024/111/НА-СТА-ТХН

Цахим хуудас:

www.audit.mn

Улаанбаатар хот

2024 он

Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал,

тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг

Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер: Ч.Болд

Утас: 260512 Цахим хаяг: boldch@audit.gov.mn

Аудитор: П.Ариунзаяа

Утас: 261628 Цахим хаяг: ariunzayap@audit.gov.mn

Гэрээгээр гүйцэтгэсэн "Конфиденсе Аудит" ХХК-ийн

Захирал: П.Ариунаа

Утас: 99994990 Цахим хаяг: info@confidenceaudit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2024.02.29 № 07/540
танай _____-ны № _____-т

УРГАМАЛ, МАЛЫН ЭРҮҮЛ АХУЙ,
ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ
ХАНГАХ АРГА ХЭРЭГСЛИЙГ
САЙЖРУУЛАХ ТӨСЛИЙН
ЗОХИЦУУЛАГЧ Э.ЦОГОО ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4 Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ургамал, малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлыг хангах арга хэрэгслийг сайжруулах төслийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Ургамал, малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлыг хангах, арга хэрэгслийг сайжруулах төслийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сум, хилийн боомтын хорио цээрийн 6,293,091.9 мянган төгрөгийн өртөгтэй барилгын суурийн цутгалтын бетон шаардлага хангахгүй байгааг мэргэжлийн байгууллага тогтоож, дүгнэлт гарснаас барилгын ажил зогсож, зээлийн гэрээнд заасан хугацаанд хэрэгжээгүйгээс АХБ төслийн дуусгавар болох хугацааг 2025 оны 11 дүгээр сар хүртэл сунгасан байна.

Аудитын гол асуудал

Барилгын хөгжлийн төвийн 2022 оны 1692/2022 тоот магадлалын дүгнэлтээр Дорноговь аймгийн Замын-үүд сумын Мэргэжлийн хяналтын болон Сайншанд сумын Мал Эмнэлгийн лабораторийн барилгын ажилд 539,065.3 мянган төгрөгийн үнийн өсөлтийн төлбөр төлөөд байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

Код	БАЛАНСЫН ЗҮЙЛ	/төгрөгөөр/	
		ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	15,741,106,310.36	17,004,743,439.87
31	МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	628,892,714.74	319,026,548.20
312	Төрийн сангийн нэгдсэн данс /төгрөгөөр/	2,998,733.17	3,724,526.68
312	Төрийн сангийн нэгдсэн данс /гадаад валютаар/	625,893,981.57	315,302,021.51
33	АВЛАГА	7,105,613.99	5,453,089.99
33100	Төлбөртэй үйлчилгээний авлага	7,105,613.99	5,453,089.99
34	УРЬДЧИЛЖ ТӨЛСӨН ТӨЛБӨР	2,722,843.12	720,000.00
34600	Урьдчилж төлсөн зардал	2,722,843.12	720,000.00
36	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	15,102,385,138.51	16,679,543,801.73
36800	Бусад эргэлтийн хөрөнгө	15,102,385,138.51	16,679,543,801.73
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ	73,111,010.56	55,237,222.00
392	Үндсэн хөрөнгө	71,041,010.56	53,627,222.00
393	Биет бус хөрөнгө	2,070,000.00	1,610,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	15,814,217,320.92	17,059,980,661.91
4	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	13,749,552.29	12,114,402.68
41362	Ажилчдын өглөг	5,149.61	-
41363	ХХОАТ-ын өглөг	3,554,836.15	3,554,836.15
41364	НДШ-ийн өглөг	10,189,566.53	8,559,566.53
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ ӨМЧИЙН ДҮН	15,800,467,768.69	17,047,866,259.23
512	Хуримтлагдсан үр дүн	15,800,467,768.69	17,047,866,259.23
51210	Өмнөх үеийн үр дүн	14,163,519,607.02	15,800,467,768.63
51220	Тайлант үеийн үр дүн	1,636,948,161.67	1,247,398,490.60
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ ӨМЧИЙН ДҮН	15,814,217,320.98	17,059,980,661.91

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	НИЙТ ОРЛОГЫН ДҮН	4,238,709,280.41	1,557,780,921.79
120044	Гадаадын тусламжийн санхүүжилт	4,064,501,867.57	1,172,039,698.00
120045	Нэмэгдсэн өртгийн албан татварын хөнгөлөлт-МУЗГ санхүүжилт	174,207,412.84	385,741,223.79
2	НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	289,531,526.10	310,881,365.90
210	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,633,712,560.32	310,881,365.90
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	213,623,896.11	171,360,000.00
210101	Үндсэн цалин	213,623,896.11	171,360,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	25,182,827.01	20,400,960.00
210201	Нийгмийн даатгалын шимтгэл	25,182,827.01	20,400,960.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	35,642,580.72	38,512,789.98
210304	Байрны түрээс	35,642,580.72	38,512,789.98
2104	Хангамж бараа материалын зардал	5,614,931.28	6,900,190.42
210401	Бичиг хэрэг	1,138,727.73	1,700,182.80
210402	Тээвэр шатахуун (зогсоол, сэлбэг хэрэгсэл)	1,216,156.73	706,952.71
210402	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,712,166.82	3,599,079.41
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх ахуйн эд зүйлс	547,880.00	893,975.50
2107	Томилолтын зардал	10,418,000.00	1,044,574.22
210702	Дотоод томилолт	10,418,000.00	1,044,574.22
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	961,324,874.11	48,021,770.41
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажлын төлбөр-Зөвлөх үйлчилгээ	942,311,688.86	19,148,170.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	16,000,000.00	26,400,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	2,401,920.00	2,087,170.41
210803	Даатгал	175,000.00	243,540.00
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээ	352,000.00	142,890.00
210808	Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээ	84,265.25	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,381,905,451.09	24,641,080.87
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,361,943,855.16	6,767,292.31
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдол	19,961,595.93	17,873,788.56
3	ҮЙЛ АЖИЛАГААНЫ ҮР ДҮН	1,604,996,720.09	1,246,899,555.89
4	ҮЙЛ АЖИЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	31,951,441.58	498,934.71
145001	Гадаад валютын ханшийн зөрүүгийн олз (бодит)	31,951,441.58	498,934.71
6	ҮЙЛ АЖИЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	1,636,948,161.67	1,247,398,490.60

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

Код	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	698,956,283.71	-
120044	Гадаадын зээлийн санхүүжилт	698,956,283.71	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН	407,659,606.64	283,103,812.21
21	Бараа, үйлчилгээний зардал	407,659,606.64	283,103,812.21
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулал	259,157,371.53	171,360,000.00
210101	Үндсэн цалин	259,157,371.53	171,360,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх	29,477,060.00	20,400,960.00
210201	Нийгмийн даатгалын шимтгэл	29,477,060.00	20,400,960.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	47,707,768.39	34,404,445.00
210304	Байрны түрээсийн хөлс	47,707,768.39	34,404,445.00
2104	Хангамж бараа материалын зардал	4,699,867.22	5,398,367.60
210401	Бичиг хэргийн материал	1,138,727.73	1,463,354.00
210402	Шуудан холбооны зардал	3,013,259.49	3,079,703.60
210402	Бага үнэтэй түргэн элэгдэх зүйл	547,880.00	855,310.00
2107	Томилолт, зочны зардал	10,418,000.00	1,617,600.00
210702	Дотоод албан томилолт	10,418,000.00	1,617,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	49,282,507.00	43,592,890.00
210801	Бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	28,122,847.00	19,148,170.00
210802	Аудитын төлбөр	18,230,740.00	24,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,401,920.00	71,280.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	175,000.00	243,540.00
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээ	352,000.00	129,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,917,032.50	6,329,549.61
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,917,032.50	6,329,549.61
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	291,296,677.07	(283,103,812.21)
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
220001	Барилга байгууламж, их засвар, захиалагчийн хяналт	34,810,204.00	27,261,289.00
7	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-34,810,204.00	(27,261,289.00)
8	САНХҮҮГИЙН МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
145001	Гадаад валютын ханшийн зөрүүгийн олз	31,951,441.58	498,934.67
225001	Гадаад валютын ханшийн зөрүүгийн гарз	-	-
9	САНХҮҮГИЙН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	31,951,441.58	498,934.67
10	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	288,437,914.65	(309,866,166.54)
11	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	340,454,800.09	628,892,714.74
12	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	628,892,714.74	319,026,548.20

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2021 оны 12 сарын 31-ны үлдэгдэл	14,163,519,606.96	14,163,519,606.96
Тайлант үеийн үр дүн	1,636,948,162.00	1,636,948,162.00
2022 оны 12 сарын 31-ны үлдэгдэл	15,800,467,768.96	15,800,467,768.63
Тайлант үеийн үр дүн	1,247,398,490.60	1,247,398,490.60
2023 оны 12 сарын 31-ны үлдэгдэл	17,047,866,259.56	17,047,866,259.56

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,501,104,000.00	1,482,404,799.21	18,699,200.79	98.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	301,104,000.00	283,103,812.21	17,341,787.79	94.2
210	БАРАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	301,104,000.00	283,103,812.21	17,341,787.79	94.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	191,809,000.00	171,360,000.00	20,449,000.00	89.3
210101	Үндсэн цалин	171,400,000.00	171,360,000.00	40,000.00	100.0
210201	Ажил олгогчоос төлөх НДШ	20,409,000.00	20,400,960.00	8,040.00	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой зардал	36,000,000.00	34,404,445.00	1,595,555.00	95.6
210304	Байрны түрээс	36,000,000.00	34,404,445.00	1,595,555.00	95.6
2104	Хангамж, бараа материалын зардал	10,110,000.00	9,938,943.60	171,056.40	98.3
210401	Бичиг хэрэг	1,500,000.00	1,463,354.00	36,646.00	97.6
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,900,000.00	2,880,279.60	19,720.40	99.3
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	860,000.00	855,310.00	4,690.00	99.5
210604	Урсгал засвар	4,850,000.00	4,740,000.00	110,000.00	97.7
2107	Томиллолт, зочны зардал	2,300,000.00	1,617,600.00	682,400.00	70.0
210701	Дотоод албан томиллолт	2,300,000.00	1,617,600.00	682,400.00	70.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажлын төлбөр	59,285,000.00	43,792,314.00	15,492,686.00	73.9
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил	34,560,000.00	19,148,170.00	15,411,830.00	55.4
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	24,000,000.00	24,000,000.00	-	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	100,000.00	71,280.00	28,720.00	71.3
210804	Тээврийн хэрэгслийн татвар	175,000.00	175,000.00	-	100.0
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	100,000.00	68,540.00	31,460.00	68.5
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	350,000.00	329,324.00	20,676.00	94.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,600,000.00	1,589,549.61	10,450.39	99.3
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,600,000.00	1,589,549.61	10,450.39	99.3
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,200,000,000.00	1,199,300,987.00	699,013.00	99.9
220001	Барилга байгууламж	1,200,000,000.00	1,199,300,987.00	699,013.00	99.9
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,577,787,769.14	1,172,039,698.00	405,748,071.14	74.0
120	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГААС	1,577,787,769.14	1,172,039,698.00	405,748,071.1	74.0
120044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	1,577,787,769.14	1,172,039,698.00	405,748,071.1	74.0
3	Ханшийн зөрүүгийн олз	-	498,934.71	-	-
4	Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл	-	628,892,714.74	-	-
5	Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	319,026,548.20	-	-
	АЖИЛЛАГСДЫН ТОО	5	5		100.0
	Удирдах ажилтан	1	1		100.0
	Гүйцэтгэх ажилтан	4	4		100.0

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар бусад хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй нийт 19,264.4 мянган төгрөгийн зөрчил² илэрсэнд нийт 1 албан шаардлага хүргүүлээ.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<i>Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил</i>								
Өмнөх жилийн аудитаар өгөгдсөн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.	1	17,704.4	-	-	1	17,704.4	-	-
ХХОАТ-ын тайланг өссөн дүнгээр илгээхдээ 1,560.0 мянган төгрөгийн цалинг дутуу илгээсэн байна.	1	1,560.0	-	-	-	-	1	1,560.0
Дүн	2	19,264.4	-	-	1	17,704.4	1	1,560.0
Нийт дүн	2	19,264.4	-	-	1	17,704.4	1	1,560.0